# СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМНЫ САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын төсвийн ерөнхийлөн захирагчийн урсгал, хөрөнгө оруулалтын зардлын жилийн болон дунд хугацааны төсвийг төлөвлөх, төсвийг зориулалтын дагуу зарцуулах, тайлагнах, эрхлэх асуудлын хүрээний хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг оновчтой боловсруулах, хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангах, хөрөнгө оруулалтын мэдээллийн цахим сан бүрдүүлэх, хөгжүүлэх, шинжилгээ хийх, мэдээллээр хангах төсвийн ерөнхийлөн захирагчийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, хяналт тавих, тайлагнах, төрийн өмчийн бүртгэлд хяналт тавих, тайлагнах, төрийн сангийн төлбөр тооцоог хийх, нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн тайланг гаргаж, хүргүүлэх ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах, төсөл, хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах, салбарын албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, харьяа төсөвт нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд хариуцах чиг үүргийг хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд: | | | | | | | |
| 1 | ***Гүйцэтгэлийн зорилт-1:*** *Соёл, спорт аялал жуулчлал залуучуудын салбарын санхүү, эдийн засгийн бодлого боловсруулах, төсвийн ерөнхийлөн захирагчийн жил бүрийн төсвийн төсөл, төсөөллийг боловсруулах, зохицуулалтыг хангах, төсвийн гүйцэтгэлийг хангуулах.* | | | | | | |
| 1.1 | **Төсвийн тухай хуулийн 22.2, Сангийн сайдын төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх 134 дүгээр журмаар**<br><br>Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын /ТЕЗ/-ын багцын батлагдсан төсвийг эдийн засгийн ангилал, хөтөлбөр, зориулалт, байгууллага, нэгжээр хуваарилан, сар, улирлын санхүүжилтийн хуваарийг боловсруулж, Сангийн сайдаар батлуулах, шаардлагатай нөхцөлд хуваарьт өөрчлөлт оруулах саналыг боловсруулан хүргүүлж, батлуулах, хяналт тавих; | ТЕЗ/-ын б агцын батлагдсан санхүүжилтийн хуваарь | -Нийт 525.3 тэрбум төгрөг<br>-Урсгал зардал 380.1 тэрбум төгрөг<br>-Хөрөнгө оруулалт 145.2 тэрбум төгрөг | -Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулсан албан бичиг | ССАЖЗ-ын төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт 2025 онд 525.3 тэрбум төгрөг батлагдсанаас урсгал зардал 380.1 тэрбум төгрөг, улсын төсвийн хөрөнгө оруулалт 145.2 тэрбум төгрөгөөр батлагдсан. Үүнээс соёл, спортын харьяа байгууллагууд болон 21 аймгийн орон нутгийн 403 байгууллагын 2025 оны төсөв, санхүүжилтийн сар улирлын хуваарийн саналыг нэгж байгууллагуудаас авч хянаж, нэгтгэн боловсруулж Сангийн сайдад албан бичгээр хүргүүлсэн. Мөн төсвийн төлөвлөлтийн программд шивж оруулсан. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаарах зарим байгууллагуудын биелэлтэд хяналт тавьж дутагдаж буй 2025 оны батлагдсан төсвийн 1-6 дугаар сарын хуваарьт өөрчлөлт оруулах саналыг Сангийн яаманд 2025 он 01 дүгээр сарын 30-ны | 01-12 сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | өдрийн 01/315, 2025 он 02 дугаар сарын 28-ны өдрийн 01/656, 2025 он 03 дугаар сарын 31-ны өдрийн 01/877, 2025 он 05 дугаар сарын 01-ны өдрийн 01/1268, 2025 он 05 дугээр сарын 20-ны өдрийн 01/1479, 2025 он 06 дугаар сарын 04-ны өдрийн 01/1668, тоот албан бичгээр хүргүүлж, төсвийн хуваарийг батлуулж, тэнцвэрт байдлыг хангуулж ажилласан. | | |
| 1.2 | **Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.3.6,**<br><br>Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд (ТЕЗ)-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаар боловсруулах; | -2026 оны боловсруулсан төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаар боловсруулсан, хүргүүлсэн санал | ССАЖЗ-н сайдын багцын 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл 943.7 тэрбум төгрөг хязгаарын санал 827.4 тэрбум төгрөг. | Төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулсан баримт бичиг-1 Төсвийн хязгаар боловсруулсан баримт бичиг-1 | Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 оны дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд соёлын бүтээлч үйлдвэрлэлийг нэмэгдүүлж эдийн засгийн эргэлтэд оруулах, соёл, спортын салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлж, үр дүнд суурилсан цалин хангамжийг авахад дараах үндсэн зарчмыг баримталлаа. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа-2050", Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжээгүй арга хэмжээнүүд, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны 2025-2028 оны стратеги төлөвлөгөөнд туссан зорилго, зорилт, арга хэмжээг бүрэн тусгах; Салбарын хууль эрх зүйн баримт бичиг, Засгийн газрын тогтоол шийдвэрийн биелэлт, хэрэгжилтийг хангах;Салбарын албан хаагчдын цалин хөлсийг батлагдсан тогтоол шийдвэрийн хүрээнд тооцон олгох;<br>Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 оны дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг 1,523.1 тэрбум төг саналыг саналыг боловсруулсан. Төсвийн ерөнхийлөн захирагчийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд суурилан боловсруулсан 2026 оны төсвийн хязгаарын саналыг 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 1/1726 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 оны нийт зардлын хязгаарын саналыг | 03-06 сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | салбарын хэмжээнд 2025 оны батлагдсан төсвөөс 382.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, нийт 1,378.1 тэрбум төгрөг байхаар арга хэмжээг төлөвлөлж боловсруулла. Үүнээс: Урсгал зардалд 762.8 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 615.3 тэрбум төгрөгөөр тооцсон. | | |
| 1.3 | **Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.3.6,**<br><br>**Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.3 дахь заалтаар**<br><br>Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд (ТЕЗ)-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийг нэгтгэн боловсруулж холбогдох тооцоо, судалгаа, тайлбар танилцуулгыг Сангийн яаманд хүргүүлэх; | -2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсвийн төсөөллийг боловсруулсан, хүргүүлсэн санал | -Нийт 525.3 тэрбум төгрөг<br>-Урсгал зардал 380.1 тэрбум төгрөг<br>-Хөрөнгө оруулалт 145.2 тэрбум төгрөг | Төсвийн төсөл боловсруулсан баримт бичиг-1 | Хуулийн хугацаа болоогүй. | 07-12 сар | 100% |
| 1.4 | **Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.3.6,**<br><br>**Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль**<br><br>Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд 2025 оны батлагдсан төсвийн хэрэгжилтийг зохицуулах; удирдлага зохион байгуулалтаар хангах; | Гүйцэтгэлийн хувиар | ССАЖЗ сайд (ТЕЗ)-ын 2025 оны батлагдсан төсөв-525.3 тэрбум төгрөг. | -Гүйцэтгэл 90-100 хувь | Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын багцын төсөвт 2025 онд 525.3 тэрбум төгрөг батлагдсан. Үүнээс урсгал зардал 380.1 тэрбум төгрөг, хөрөнгийн зардал 145.2 тэрбум төгрөг батлагдсанаас 6 дугаар сарын 9-ний өдрийн байдлаар 142.4 тэрбум төгрөгийн буюу 27.1 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс Урсгал зардал: 122.1 тэрбум төгрөг буюу 32.1 хувь, Хөрөнгийн зардал: 20.2 тэрбум төгрөг буюу 14.0 хувийн гүйцэтгэлтэй тус тус гарсан байна.<br>ССАЖЗ-ын төсвийн ерөнхийлөн захирагчийн төвийн 27 байгууллага, спортын төвлөрүүлэн захирагч, орон нутгийн харьяа 21 аймгийн соёл урлагийн газар, нийслэлийн соёл урлагийн газар орон нутгийн 403 байгууллагын | 01-12 сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгууллага тус бүрийн 3 зориулалт дээр нийт 45 эдийн засгийн ангиллаар нийт 100 мянган мөр багана санхүүжилтыг олгохоор тусгаж ССАЖЗ-ын сайдын батлагдсан дараах тушаалаар санхүүжилтыг олгосон. 1-р сард 2025 оны А/01 тоот болох 11.6 тэрбум төгрөг. 2-р сард 2025 оны А/25 тоот болох 13.3 тэрбум төгрөг. 3-р сард 2025 оны А/67 тоот болох 14.4 тэрбум төгрөг. 4-р сард 2025 оны А/103 тоот болох 11.9 тэрбум төгрөг 5-р сард 2025 оны А/166 тоот болох 11.6 тэрбум төгрөг 6-р сард 2025 оны А/228 тоот болох 14.4 тэрбум төгрөг бүхийн 1-6 дугаар саруудад 403 байгууллагад 4495 албан хаагчдын цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал, НДШ болон байгууллагын хэвийн үйл ажиллагааны зардал, ажил олгогчоос олгох нийгмийн баталгааны хүрээнд олгож тэтгэвэр тэтгэмжийн зардлуудад нийт 77.2 тэрбум төгрөгийн санхүүжилтыг олгож мэргэжил арга зүйгээр ханган ажилласан. Сайдын болон ТНБД-ын тушаал шийдвэрийн дагуу “Монгол” нүүдэлчин фестивальд 1.0 тэрбум төгрөг, “Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн Бүгд Найрамдах Чех улс, Бүгд Найрамдах Польш Улсад хийх төрийн айлчлалын хүрээнд "Морин хуур" найрал хөгжмийн "Монголын сайхан орон" тоглолтыг зохион байгуулахад шаардагдах зардалд 395.8 сая төгрөг гэх мэт хөтөлбөр арга хэмжээний зардалд нийт 2026 оны 6 сарын 09-ны өдрийн байдлаар 5.1 тэрбум төгрөг зарцуулаад байна. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 82, 128 дугаар тогтоолуудаар төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалин 10%, орон нутагт ажилласны нэмэгдэл 20-40%-иар нэмэгдүүлэх, Соёлын сайд, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2024 оны А/166, А/63, А/73 дугаар тушаалаар “Соёл, урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хаагчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт"-ийг баталсан талаар 2025 оны төсвийн хуваарийг хүргүүлсэн. Дээрх хамтарсан тушаалтай холбогдуулан "Соёлын ажилтны ур чадварыг үнэлж дүгнэх, нэмэгдэл олгох үйл ажиллагааг батлагдсан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэх, Ур чадварын нэмэгдэл хөлсийг олгохдоо үнэлгээ хийсэн ажлын хэсгийн санал дүгнэлт, Соёл урлагийн газрын дарга болон Төсвийн шууд захирагч нарын тушаал шийдвэр, нотлох баримтыг үндэслэн үнэн зөв хийх, Албан хаагчдын ур чадварын нэмэгдлийг тухайн жилийн батлагдсан төсөв, сар улирлын хуваарьт багтаан олгох, Мэргэжлийн ур чадварын чанар, нэр хүндийг бууруулахгүй, албан хаагчдад хавтгайруулан олгохгүй байх талаар чиглэл өгсөн. Монгол Улсын засгийн газрын "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх, төсвийн шинэчлэлийг эрчимжүүлэх, соёлын болон бусад салбарын хууль тогтоомжийн хүрээнд төсөв санхүүг захиран зарцуулж, төсвийн сахилга батыг ханган ажиллах талаар орон нутгийн байгууллагуудад холбогдох чиглэлийг өгсөн. | | |
| 1.5 | **Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.3.6,**<br><br>**Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль**<br>**Соёлын сайдын 2023 оны 390 дугаар тушаалаар батлагдсан "Соёлын байгууллагын үр дүнд суурилсан санхүүжилтийн аргачлал"**<br><br>Соёлын байгууллагуудын үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн аргачлалын хүрээнд 2024 оны | Үр дүнгийн нэмэлт санхүүжилт үнэлж олгосон байна. | Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт-8.0 тэрбум төгрөг | Үр дүнгийн нэмэлт санхүүжилт үнэлж олгосон байна. | Соёлын байгууллагуудын төвийн болон орон нутгийн 421 байгууллагын 2024 оны үйл ажиллагааг байгууллага тус бүрийн санхүүгийн үзүүлэлт, жилийн эцэст үнэлэгдсэн байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, хүний нөөцийн хөгжлийн үзүүлэлтүүдийг байгууллагуудын ангиллаар нь ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудыг хооронд нь харьцуулан үнэлгээг хийж, ССАЖЗ-ын сайдын 2025 оны 5 дугаар сарын А/212 тоот тушаалаар баталж санхүүжилтийг олгосон. Санхүүгийн үзүүлэлтийг 2023, 2024 оны нэгдсэн тайлангаас бодит үнэн зөв тоогоор нэгтгэсэн. 2024 оны үйл ажиллагаанаас олсон орлоготой уялдуулж | 04-06 сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагын гүйцэтгэлийн үр дүнг үнэлж, нэмэлт санхүүжилтийг олгох. | | | | үнэлсэн. Үйлчилгээний хүртээмж: Нийт үйлчлүүлэгчдийн тоог ССАЖЗ-ын сайдын 2024 оны жилийн эцсийн статистик нэгдсэн мэдээнээс нэгтгэсэн бөгөөд үйлчилгээний хүртээмжийг 150%-дээш үзүүлэлтийг хүн амын 120%-р, 100-149% хүртэл үзүүлэлтийг хүн амын 100%-р, 99%-с доош байгааг статистик нэгдсэн мэдээний дүнгээр нь тооцсон. Ур чадвар дээшлүүлсэн албан хаагчдын тоо: Байгууллагын үндсэн албан хаагчдаас боловсролын цол зэрэг ахиулах, мэргэшүүлэх богино болон дунд хугацааны сургалт, хөтөлбөрт хамрагдсан албан хаагчдын тоогоор тооцсон. Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ: 2024 оны жилийн эцэст гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр үнэлэгдсэн байгууллагын үнэлгээгээр тооцсон. Үр дүнд суурилсан санхүүжилтээр нийт соёлын 421 байгууллагат 8.0 тэрбум төгрөгийн санхүүжилтыг дараах байдлаар санхүүжүүлсэн. Үүнд: Сайдын шууд харьяа соёлын нийт 18 байгууллагаас 1. Театр чуулгын 6 байгууллагаас хамгийн ихэд нь Үндэсний урлагийн их театрт 269.5 сая төгрөг, хамгийн бага нь Хүүхэд залуучуудын театрт 262.1 сая төгрөгийг олгосон. 2.Музейн 10 байгууллагаас Чингис хаан үндэсний музейд 130.2 сая төгрөг, хамгийн бага Хөшөө цайдам музейд 124.4 сая төгрөг санхүүжилт олгосон, 3. Номын сангийн 2 байгууллагат 160 сая төгрөг, 159.9 сая төгрөгийг үр дүнд суурилсан санхүүжилтээр олгосон. Орон нутгийн нийт 403 байгууллагаас 1. Театр чуулгын 24 байгууллагаас хамгийн их нь Увс аймгийн Хөгжимт драмын театр т 77.1 сая төгрөг, хамгийн бага нь Баян-Өлгий аймгийн Хөгжимт драмын театрт 28.4 сая төгрөг 2. Музейн 23 байгууллагаас хамгийн их нь Өвөрхангай аймгийн Эрдэнэзуу музей 48.5 сая төгрөг , хамгийн багад нь 7.9 сая төгрөгийг Сэлэнгэ аймгийн Музейд 3. Номын сангийн 23 байгууллагаас хамгийн их нь Хэнтий аймгийн Номын санд | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 37.4 сая төгрөг, хамгийн бага нь Сүхбаатар аймгийн Номын санд 6.4 сая төгрөг. 4. Соёлын төвийн 333 байгууллагаас хамгийн их нь Өмнөговь аймгийн Гурвантэс соёлын төвд 42.1 сая төгрөг, хамгийн багад нь Баян-Өлгийн аймгийн Сагсай сумын соёлын төвд 0.3 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. | | |
| 1.6 | **Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.3.6,**<br><br>**Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль**<br><br>Соёл, спорт аялал жуулчлал залуучуудын байгууллагуудын санхүү бүртгэлийн албан хаагчид болон нягтлан бодогч нарт гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн хэрэгжилт үр дүн, 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнг танилцуулах, хэлэлцүүлэг зохион байгуулах. | Сургалт хэлэлцүүлэг зохион байгуулах.<br>Оролцогчийн тоо-70 | | Сургалт хэлэлцүүлэг зохион байгуулсан байна. | Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн орон нутгийн брэндинг, бүс нутгийн онцлог, соёл, спорт, аялал жуулчлалыг бүсийн хөгжлийн бодлоготой уялдуулан урт, дунд, богино хугацаанд хэрэгжүүлэх бодлого, төлөвлөгөөг боловсруулах зорилгоор Соёл, спорт, аялал, жуулчлал, залуучуудын салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг Хангай, Хойд, Говь, Төвийн бүсэд нийт 13 аймгийн 759 албан хаагчдыг оролцуулан 4 нэгдсэн арга хэмжээг 2 дугаар улиралд багтаан зохион байгуулллагдсан. Зөвлөгөөнөөр яамны бодлогын газрын дарга, шинжээч нар салбарын бодлого, төлөвлөлтийг танилцуулсан. СХОГ-ын зүгээс 1.Төсвийн бодлого 2.2025 оны төсөв 3.Урсгал төсөв 4. Цалин хөлс 5.Үр дүнд суурилсан санхүүжилт 6.Хөрөнгө оруулалт 7.Бүсийн хөрөнгө оруулалт 8.Хөрөнгө оруулалтын хэрэгжилт 9. Цаашид анхаарах асуудал гэсэн сэдвүүдийн хүрээнд танилцуулга хийсэн. Энэхүү зөвлөгөөний агуулга нь 2025 оны төсвийн талаарх үр дүнг танилцуулахтай давхцаж буй тул 2025 оны сүүлийн хагас жилд хэлэлцүүлэгээ хийхээр төлөвлөж байна. | 6-р сар | 100% |
| 2 | ***Гүйцэтгэлийн зорилт-2*** *Захиран зарцуулах, санхүүжүүлэх, тайлагнах ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, холбогдох хууль тогтоомжийн дагуу төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх, мэдээллийн сан бүрдүүлэх, төсвийг ил тод мэдээлэх, төрийн сангийн үйл ажиллагаа эрхлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах.* | | | | | | |
| 2.1 | **Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.3.6,** | Батлагдсан төсвийн хуваарийн дагуу тухайн байгууллагын | -Улсын төсвийн 27 байгууллагын төрийн сангийн 65 данс | -Төрийн сангийн төлбөр тооцоог төлбөрийн | 2025 оны хагас жилийн байдлаар холбогдох хууль, журмын хүрээнд батлагдсан төсвийн хуваарийн дагуу Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны төрийн сангаар гүйлгээ хийдэг 28 | 01-12 сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **Төсвийн тухай хуулийн 38 дугаар зүйл, Сангийн сайдын Төрийн сангийн үйл ажиллагааны 444 дүгээр журмаар**<br><br>Харьяа байгууллагуудын төрийн сангийн төлбөр тооцоог батлагдсан төсвийн хуваарийн дагуу тухайн байгууллагын төлбөрийн шилжүүлэг баримтыг үндэслэн үнэн зөв хийж гүйцэтгэх, баталгаажуулах; | төлбөрийн шилжүүлэг баримтыг үндэслэн үнэн зөв хийж гүйцэтгэсэн байна. | -Орон нутгийн төрийн сангийн 425 данс | шилжүүлэг баримтыг үндэслэн үнэн зөв хийж гүйцэтгэсэн байна. | байгууллагын төрийн сангийн үндсэн болон нэмэлт санхүүжилтийн нийт 65 дансаар урсгал үйл ажиллагаа, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого, барьцаа хөрөнгөтэй холбоотой нийт 8,654 ширхэг, 54,253,325,254 төгрөгийн гүйлгээг анхан шатны баримтад үндэслэн төрийн сангийн төлбөр тооцооны систем хангамжаар дамжуулан төлбөр тооцоог хийж гүйцэтгэн баталгаажуулсан. | | |
| 2.2 | **Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль**<br><br>Орон нутгийн соёлын байгууллагуудын сар улирлын санхүүжилтийн баазыг бэлтгэж, Сайдын тушаалаар батлуулах, санхүүжилтийг олгох. | Батлагдсан төсвийн хуваарийг тушаалаар батлуулж, баазыг бэлтгэж санхүүжилтийг олгосон байна. | Гүйцэтгэлээр олгох санхүүжилт-153.9 тэрбум төгрөг | Төсвийн хуваарийг батлуулж, санхүүжилт олгосон байна. | Монгол улсын 2025 оны төсвийн тухай хуульд батлагдсан ССАЖЗ-ын сайдын багцын урсгал зардалд хамааралтай орон нутгийн 21 аймгийн 403 байгууллагын байгууллага тус бүрийн 3 зориулалт дээр 45 эдийн засгийн ангиллаар нийт 100 мянган мөр багана санхүүжилтыг олгохоор тусгаж ССАЖЗ-ын сайдын батлагдсан дараах тушаалаар санхүүжилтыг олгосон. 1-р сард 2025 оны А/01 тоот тушаал 11.6 тэрбум төгрөг, 2-р сард 2025 оны А/25 тоот тушаал 13.3 тэрбум төгрөг, 3-р сард 2025 оны А/67 тоот тушаал 14.4 тэрбум төгрөг, 4-р сард 2025 оны А/103 тоот тушаал 11.9 тэрбум төгрөг, 5-р сард 2025 оны А/166 тоот болох 11.6 тэрбум төгрөг, 6-р сард 2025 оны А/228 тоот тушаал 14.4 тэрбум төгрөгийг эхний хагас жилийн байдлаар 403 байгууллагад 4,495 албан хаагчдын цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал, НДШ болон байгууллагын хэвийн үйл ажиллагааны зардал, ажил олгогчоос олгох нийгмийн баталгааны хүрээнд олгож тэтгэвэр тэтгэмжийн зардлуудад нийт 77.2 тэрбум төгрөгийн санхүүжилтыг олгоод байна. | 01-12 сар | 100% |
| 2.3 | **Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.3.6,** | Санхүүжилтийн гүйцэтгэлийн хувь | 2024 оны батлагдсан төсөв-145.2 тэрбум төгрөг | -Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн хувиар | Соёл, спортын, аялал жуулчлал, залуучуудын салбарын хөрөнгө оруулалтад 2025 онд нийт 52 төсөл арга хэмжээнд 145.2 тэрбум төгрөг батлагдсан. Соёл, аялал жуулчлалын хөрөнгө оруулалтын | 01-12 сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоол.**<br><br>Улсын төсвөөс санхүүжих төсөл, арга хэмжээний барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг хүлээн авах, хянах, баталгаажуулах, санхүүжүүлэх, зарцуулалтад хяналт тавих, тайлагнах; | -Хянасан гүйцэтгэлийн тоо | | -Төсөл арга хэмжээний тоо-52 | 100900034301 тоот данснаас 2025 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 8 компанийн 11.7 тэрбум төгрөг, спортын хөрөнгө оруулалтын 100900034303 тоот данснаас 2 компанийн 2.6 тэрбум төгрөг, орон нутгийн эрх шилжсэн хөрөнгө оруулалтаас 5.9 тэрбум төгрөг нийт 20.2 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарч 14 хувьтай байна. Ангиллаар нь авч үзвэл:<br>Барилга байгууламж: 17,332.4 сая төгрөг<br>Тоног төхөөрөмж: 2,889.6 сая төгрөг<br>Тухай бүр Хөрөнгө оруулалтын хэлтсээс баталгаажуулж ирсэн гүйцэтгэлийг хянаж холбогдох захиалагч болон зохиогчийн хяналт, чанарын баталгааг суутган гүйцэтгэгч компанид 12.1 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийн санхүүжилтийг олгосон. | | |
| 2.4 | **Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.3.6,**<br><br>**Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль,**<br><br>Сайдын багцад батлагдсан хөтөлбөр арга хэмжээний санхүүжилтийг хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих; | -Хөтөлбөр арга хэмжээний тоо<br>-Тушаалын тоо | 2025 онд Хөтөлбөр арга хэмжээ 68.5 тэрбум төгрөг. | Хөтөлбөр арга хэмжээний санхүүжилтэд хяналт тавьсан гүйцэтгэлийн тоо, хувиар | Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын шууд буюу хөтөлбөр арга хэмжээнд 2025 онд 97.9 тэрбум төгрөг соёл урлаг, аялал жуулчлал, залуучууд болон оюутнууд, биеийн тамир, спорт гэсэн 4 хөтөлбөр, 24 зориулалтаар батлагдсан. Дээрх батлагдсан төсвийг ССАЖЗ-ын сайдын 2025 оны “Хөтөлбөр арга хэмжээний төсвийн хуваарилалт батлах тухай” А/04 тоот тушаалуудыг тус тус үндэслэж холбогдох газар, хэлтсээс тухай бүр гарган боловсруулан, батлуулсан тушаалуудын санхүүжилтийг олгосон байна. Тайлант хугацаанд буюу 2025 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн байдлаар 8 арга хэмжээний 5.1 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан. Мөн 21 тушаалаар 12.6 тэрбум төгрөгийг төсвийн хуваарийн өөрчлөлтөөр тухайн байгууллагын үндсэн дансанд шилжүүлсэн. Арга хэмжээ тус бүрээр нь авч үзвэл: Соёл урлаг хөтөлбөрийн Үндсэн үйл ажиллагааны зардал – 1,670.4 сая төгрөг, Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас зардалд-92.7 сая төгрөг, Гадаад, дотоодод зохиогдох соёл урлагийн арга хэмжээ – 648.1 сая төгрөг, | 01-12 сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Цахим соёл хөтөлбөр – 8.6 сая төгрөг, Монгол Улсын Олон улс дахь сурталчилгаа, мэдээллийн үндэсний хорооны үйл ажиллагааны хэрэгжилт – 192.9 сая төгрөг, Аялал жуулчлал хөтөлбөрийн Үндсэн үйл ажиллагааны зардалд-1,253.6 сая төгрөг, Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх-1,089.0 сая төгрөг, Соёлын өв хөтөлбөрийн Түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах зардалд-182.0 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон байна. ССАЖЗ сайдын эрхлэх бодлогын асуудлын төсвийн талаар Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Зарлагын хэлтсийн мэргэжилтэнгүүдтэй ССАЖЗЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, холбогдох мэргэжилтэнгүүдтэй Сайдын баталсан "Зардал баталж, Эрх шилжүүлсэн тухай" дараах байгууллагуудад тушаалын санхүүжилтүүдийг шийдвэрлэсэн. Нийт ХАХ -ээс 20 тушаалаар харьяа байгууллагуудад 12.8 тэрбум төгрөгийн эрх шилжүүлж санхүүжүүлж гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаж бна | | |
| 2.5 | **Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.3.6,**<br><br>**Засгийн газрын 430, 253, 397, 495, 249 тоот тогтоолоор**<br><br>Сайдын багцын барьцаа хөрөнгө, техник хяналтын зардлын хэрэгжилтийн хангах, санхүүжилтийг олгох, гүйцэтгэлийг хянах; | -Барьцаанаас чөлөөлсөн төсөл арга хэмжээ<br><br>-Техник хяналтын зардлын дүн | -Барьцаа хөрөнгө дансанд-25.8 тэрбум төгрөг<br><br>-Техник хяналт-390.7 сая төгрөг | -Барьцаа хөрөнгө данснаас чөлөөлсөн гүйцэтгэлийн тоо Тушаалаар гарсан техник хяналтын зардлын мөнгөн дүн | Соёл, аялал жуулчлалын барьцаа хөрөнгийн дансанд 2025 оны 01 дүгээр сарын 01-ны өдрийн байдлаар 2021 оны ЗГ-ын 397 дугаар тогтоолын үлдэгдэл 1 төсөл арга хэмжээний 203.4 сая төгрөг, 2022 оны ЗГ-ын 495 дугаар тогтоолын үлдэгдэл 4 төсөл арга хэмжээний 2,109.5 сая төгрөг, 2023 оны 456 дугаар тогтоолын үлдэгдэл 8 төсөл арга хэмжээний 3,331.3 сая, 2024 оны 249 дүгээр тогтоолын үлдэгдэл 22 төсөл арга хэмжээний 11,021.9 сая чанарын баталгааны 1,950.1 сая төгрөг нийт тус дансанд 18,616.4 сая төгрөг байна. Үүнээс. Засгийн газрын 2024 оны 249 дүгээр тогтоолын дагуу 9 төсөл арга хэмжээний 2,456.1 сая төгрөгийн санхүүжилтийг Сангийн яамнаас | 01-12 сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | санхүүжилтийн эрх нээгдсэний дагуу гүйцэтгэгчид холбогдох гүйцэтгэл, гэрээ, актыг үндэслэн олгосон. Мөн Үндэсний аудитын газрын 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн СНАГ-2025/115/НА/СТА-ТШЗ актын дагуу 861.9 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн. Спортын барьцаа хөрөнгийн дансанд 2025 оны 01 дүгээр сарын 01-ны өдрийн байдлаар 7,227.9 сая төгрөг байснаас Засгийн газрын 2023 оны 456 дугаар тогтоолын дагуу 1 төсөл арга хэмжээний 647.8 сая төгрөг, 2024 оны 249 дүгээр тогтоолын дагуу 703.2 сая, Үндэсний аудитын газрын 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн СНАГ-2025/115/НА/СТА-ТШЗ актын дагуу 219.9 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн. Техник хяналтын данснаас ССАЖЗ-ын сайдын "Техник хяналтын зардлын хуваарь батлах тухай" тушаалын төсөл боловсруулж салбарын 2023, 2024 оны төсөвт батлагдсан төсөл арга хэмжээний захиалагчийн барилгын техник хяналтын ашиглалтын зардлын хуваариалалтад 390.7 сая төгрөгийн 2023 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/08 тоот тушаал батлагдсан. Дээрх тушаалын дагуу 2025 оны 6 дугаар сарын 09-ны өдрийн байдлаар гэрээт инженерүүдийн цалин хөлс түүнтэй холбогдох зардлууд болон бичиг хэргийн материалын зардалд 70.7 сая төгрөгийн санхүүжилтийг холбогдох анхан шатны баримтанд үндэслэн олгосон байна. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны "Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" 249 дугаар тогтоолыг үндэслэн Сангийн яамны ТНБД-ын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн "Тогтоолын хэрэгжилтийг хангах тухай " 03/278 дугаар албан бичгээр Монгол Улсын 2024 оны төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих төсөл, арга хэмжээний санхүүжилтийн үлдэгдлийг барьцаа хөрөнгийн дансанд нийт 47 төсөл, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.6 | | | | | арга хэмжээний 36,528.8 сая төгрөг байршуулсан мэдээллийг ирүүлсэн.<br>ССАЖЗС-ын багцын төсөвт 2025 онд эрх шилжээгүй, яамны хөрөнгө оруулалтын 100900034301, 100900034302 тоот данснаас санхүүжих 111,700.0 сая төгрөг, үүнээс 06 дугаар сарын 09-ний байдлаар 11,764.4 сая төгрөг буюу 10%-ийн гүйцэтгэлтэй санхүүжсэн байна.<br>Хавсралт: 3 файл | | |
| 2.6 | **Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль.**<br>Гүйцэтгэгч компаниудын арилжааны банканд байршуулсан Гүйцэтгэлийн баталгаа, чанарын баталгаа, урьдчилгаа төлбөрийн баталгааг чөлөөлөх, өөрчлөлт оруулах асуудлыг хууль журмын дагуу шийдвэрлэх; | Гэрээ дүгнэсэн акт, 2 жилээс дээс хугацаанд хэрэгжих төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн хувь. | Гүйцэтгэгч байгууллагын хүсэлтийг судалж, тухай бүр нь шийдвэрлэсэн. | Хууль, журмын хүрээнд тухай бүр шийдвэрлэсэн байна. | Гүйцэтгэгч компаниудын арилжааны банканд байршуулсан Гүйцэтгэлийн баталгаа, чанарын баталгаа, урьдчилгаа төлбөрийн баталгааг хууль, журмын хүрээнд гүйцэтгэгчийн хүсэлт болон бусад баримт бичгийг үндэслэн тухай бүрд чөлөөлөн шийдвэрлэж байна. | 01-12 сар | 100% |
| 2.7 | **Төсвийн тухай хууль, Аудитын тухай хуулиар**<br><br>Улсын төсвийн хөрөнгө оруулалт, барьцаа хөрөнгө, техник хяналт, Сайдын багцын хөтөлбөр арга хэмжээ, соёл урлаг хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланг гаргаж, хуулийн хугацаанд холбогдох газарт хүргүүлнэ. | Хугацаандаа чанартай гүйцэтгэсэн байна. | 2024 оны жилийн эцсийн тайлан<br>2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан | Тайлангийн тоо хагас жилээр-5<br>Бүтэн жилээр-5 | 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн дагуу гарган Үндэсний аудитын газар хүргүүлж аудит хийлгэж, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын багцын тайланд нэгтгэн боловсруулж Сангийн яаманд хүргүүлэн Засгийн газрын нэгдсэн тайланд нэгтгүүлсэн. Соёл, спортын Хөрөнгө оруулалт, соёл, спортын барьцаа хөрөнгө, соёл, спортын техник хяналт, ССАЖЗ-ын сайдын шууд, Соёл урлагийг дэмжих сан нь сайдын багцын нэгдсэн тайланд орж аудит хийгдэж түүвэрт хамрагдсан. | 01-12 сар | 100% |
| 2.8 | **Төсвийн тухай хууль, Аудитын тухай хуулиар**<br><br>Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаарах урсгал болон хөрөнгө оруулалтын зарцуулалт үр дүнгийн санхүүгийн нэгтгэсэн | -Гэрчилгээ<br>-<br>Хэрэгжилтийн хувь | Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг | Үндэсний аудитын газрын гэрчилгээ-1<br>Зөвлөмж, акт албан | ССАЖЗСайдын ТЕЗ-ийн багцын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд ҮАГ-аас СНАГ-2025/20/НА-СТА-ТЕЗ кодтой аудит орж 2025.04.25-ны өдрийн 1602 тоот бичгээр "Хязгаарлалттай дүгнэлт" ирүүлсэн. Санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 | 01-12 сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тайланг хууль тогтоомжийн дагуу хүлээн авч, хагас бүтэн жилээр нэгтгэн холбогдох байгууллагуудад хүргүүлж, аудит хийлгэн баталгаажуулах; | -Зөвлөмж, акт, албан шаардлага | -Санхүүгийн нэгдсэн тайлан тэнцэл санхүүгийн аудит хийлгэсэн. | шаардлагын тоо | дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн. Нэгтгэсэн тайланд харьяа 496 байгууллага, сан, данс нэгтгэгдэхээс 161 байгууллагад дүгнэлт гаргаж, 1 байгууллагад дүгнэлт өгөхөөс татгалзаж, 333 байгууллагыг түүвэрт хамруулж, 2 байгууллага тодорхой шалтгааны улмаас аудитад хамрагдаагүй. Нэгтгэсэн тайлангийн аудитаар 36,390.7 сая төгрөгийн 850 зөрчил илэрснээс хууль хяналтын байгууллагад 3 байгууллагын 236 сая төгрөгийн зөрчлийг шилжүүлж, 1,368.7 төгрөгийг төсөвт төвлөрүүлэх 194 төлбөрийн акт тогтоож, 28,883.4 сая төгрөгийн 277 зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлж, 5,902.5 сая төгрөгийн 363 зөрчлийг арилгах зөвлөмж өгч, эрхэлсэн ажилдаа хариуцлагагүй хандсан 11 албан хаагчид хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн байна. Аудитаар Биеийн тамир, спортын улсын хороо "Сөрөг" дүгнэлт, Соёл урлагийн газрын төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланд "Татгалзсан" дүгнэлт өгсөн зэрэг нь нэгтгэсэн тайланд хязгаарлалттай дүгнэлт авахад голчлон нөлөөлсөн байна. | | |
| 2.9 | **Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоолоор**<br><br>Соёлын төсвийн ерөнхийлөн захирагчийн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023-2024 онд ашиглалтад орсон барилга байгууламжийг балансаас баланс хооронд шилжүүлэх асуудлыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлж биелэлтийг ханган ажиллана. | Ашиглалтад орсон барилгыг бүрэн шилжүүлсэн байна. | - | Төрийн өмчийн тогтоолын тоо | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд ашиглалтад орсон 15 төсөл арга хэмжээний 51,752.4 сая төгрөг ашиглагч байгууллагад шилжүүлэх саналыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлэхээр баримт материалын бүрдлийн ханган ажиллаж байна. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 672 дугаар тогтоолоор 2023 оны хөрөнгө оруулалтаар Соёлын сайд /хуучнаар/-ын багцад санхүүжиж бий болсон 65 нэрийн 32,672.4 сая төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгэсэн. | 01-12 сар | 95% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Мөн 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 742 дугаар тогтоолоор 7 нэрийн 5,462.6 сая төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгэсэн. | | |
| 2.10 | **Шилэн дансны тухай хуулиар**<br><br>Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын салбарын 2025 оны төсвийг ил тод мэдээлэх, Төсвийн ерөнхийлөн захирагч, шууд захирагчийн шилэн дансны мэдээлэл оруулах; | Шилэн дансны 2025 оны мэдээ мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулж үнэлүүлэх.<br>Шилэн дансны цахим хуудас дахь Соёлын яамны мэдээллийн цонхонд байршсан мэдээлэл тоо | Шилэн дансны хуулийн дагуу Сайдын багцын батлагдсан төсвийн хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагч, шууд захирагчийн шилэн дансанд байршуулсан. | -Сар бүр оруулах мэдээлэл-12<br>-Улирал бүр оруулах мэдээлэл-4<br>Бүтэн жилээр оруулах мэдээлэл-1 | Шилэн дансны тухай хууль болон Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн А/109 тоот “Тушаалд өөрчлөлт оруулах тухай” тушаалын хавсралтад заагдсан мэдээллийг Сайдын багцын батлагдсан төсвийн хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагч, шууд захирагчийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ хэтрэлт хэмнэлтийн тайлбар, улсын төсвийн хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гүйцэтгэл болон бусад мэдээ мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд тухай бүр нь байршуулсан. Мөн тухай бүр, сар бүр, жилээр оруулах мэдээ мэдээллийг давхардсан тоогоор шилэн дансны сайтад 75 мэдээллийг байршуулж ажилласан. | 01-12 сар | 100% |
| 2.11 | **Төсвийн тухай хууль, Сангийн сайдын Төрийн сангийн үйл ажиллагааны 444 дүгээр журмаар**<br><br>Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын багцын төсвийн гүйцэтгэлийн мэдээ тайланг нэгтгэн хуулийн дагуу гаргаж тайлагнах, хяналт тавин, орлогын хуваарилалт хийх. | Сайдын багцын төсвийн гүйцэтгэлийн мэдээг нэгтгэн тайлагнасан. хугацаанд нь тайлагнаж хянасан байна. | -Нийт 525.3 тэрбум төгрөг<br>-Урсгал зардал 380.1 тэрбум төгрөг<br>-Хөрөнгө оруулалт 145.2 тэрбум төгрөг | -Сайдын багцын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан | Харьяа 28 байгууллагын үндсэн болон нэмэлт санхүүжилтийн нийт 65 дансны төсвийн гүйцэтгэлийн тайланг сар бүрийн 2-ны дотор зардал тус бүрээр тулган баталгаажуулж авч, алдааг тухай бүрд нь залруулж, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын ТЕЗ-ын төсвийн гүйцэтгэлийн мэдээний нэгтгэлийг гаргаж Сангийн яаманд 11/31, 11/392, 11/1306, 11/1692 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн. Сангийн сайдын 282 дугаар тушаалын дагуу нэмэлт санхүүжилтийн дансанд эрх нээгдсэн нэмэлт үйл ажиллагааны орлогын хуваарилалтыг тухай бүр төрийн сангийн систем хангамжид хийн ажилласан. 2025 оны 6 дугаар сарын байдлаар 14.3 тэрбум төгрөгийн орлогын хуваарилалт хийсэн байна | 01-12 сар | 100% |
| 2.12 | **Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.1, Соёлын яамны 2021-2024 оны стратегийн зорилт 7 дах хэсэг.** | Худалдан авах ажиллагаа зохион байгуулах төсөл, арга | Нээлттэй тендерийн тоо төсөл арга хэмжээ. Үүнээс Соёлын яам 3. | Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй 2024.05.01- | ССАЖЗ-дын сайдын 2025 оны А/02 төлөвлөгөөг батлуулж, Таравчамбуулин хийдийн авга дуганыг сэргээн засварлах /Архангай, Батцэнгэл сум/ төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтад “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн | 01-12 сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад батлагдсан улсын төсвийн хөрөнгөөр 2025 хэрэгжих төсөл арга хэмжээний худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хэрэгжилтийг хангах; | хэмжээний тоо | | ний дотор гэрээ байгуулсан байна. | “Сүлдпроект” ХХК шалгарч ТХААГ-аас гэрээ байгуулах зөвлөмж ирүүлээд гэрээ байгуулагдаж байна.<br>Харьяа байгууллагуудын 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах холбогдох баримт бичгийг tender.gov.mn цахим хаягт байршуулж ажилласан | | |
| 2.13 | Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны худалдан авах ажиллагааны тайланг нэгтгэж, Сангийн яаманд хүргүүлэх; | 2024.01.15-ны дотор. | Жил бүр хуулийн хугацаанд хүргүүлсэн. | Тайланг хугацаанд нь хүргүүлсэн байна. | Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны худалдан авах ажиллагааны тайланг нэгтгэж, Сангийн яаманд хүргүүлсэн. | 01-12 сар | 100% |
| ***Гүйцэтгэлийн зорилт-3*** *Олон улсын стандарт, шаардлагад нийцсэн соёлын барилга байгууламжийг ашиглалтад оруулж, орон нутгийн соёл, урлагийн байгууллагын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.* | | | | | | | |
| 3.1 | **Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт.**<br><br>Байгалийн түүхийн шинэ музейн барилгыг ажлыг үргэлжлүүлэх; | Батлагдсан төсөв- 41,006.6 сая төгрөгийг санхүүжүүлнэ. | Барилгын зураг төсөв бэлэн болсон. Төсөв 138.3 тэрбум төгрөг батлагдсан. | Барилга угсралтын ажлыг 50%-д хүргэнэ. | Соёлын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар XIV.1.15-д “Байгалийн түүхийн музейн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/” Захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт “ББСМО” ХХК шалгарч, төсөвт өртөгийг 30 тэрбум төгрөгөөр батлуулсан, 6 дугаар сарын байдлаар 8.1 тэрбум төгрөгийн гүйцэтгэл олгож, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус барилга угсралтын ажлыг Содон номин констракшн ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд барилгын ажил 45 хувийн гүйцэтгэлтэй байна. | 01-12 сар | 80% |
| 3.2 | **Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.1.4 дэх заалт.**<br><br>Үндэсний урлагийн их театрын барилгын Техник, эдийн засгийн үндэслэлийг батлуулах болон газар сонгох | ТЭЗҮ-ийг шаардлагын хэмжээнд боловсруулна. | Техник эдийн засгийн судалгаа хийгдсэн. | ТЭЗҮ-ийг хүлээн авч, барилгын ажлыг эхлэх бэлтгэл хангагдана. | Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас санал болгосон Богдхан уулын Дархан цаазат газрын хамгаалалтын бүс /Яармагт/ 10 га газар, Сүхбаатарын талбайгаас 13 км-ын ойр орчмын хэтийн төлөвлөлт, хүн амын судалгаа, инженер геологийн дүгнэлт, газрын кадастр зэрэг мэдээллийг Соёлын сайдын 2024.02.07-ны өдрийн 1/341 тоот албан бичгээр МУ-д суугаа БНХАУ-ны элчин сайдын яаманд хүргүүлсэн. Ажлын хэсгийн хурлыг зохион байгуулсан ба газрын асуудал шийдэгдээгүй байна. | 01-06 сар | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3 | **Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт.**<br><br>Монголын Үндэсний археологи, палеонтологи, угсаатны музей, лаборатори /Төв, Зуунмод сум/ барих; | Батлагдсан төсөв- 8,137.3 сая төгрөгийг санхүүжүүлнэ. | Барилга угсралтын ажил 70 хувьтай. | Барилга угсралтыг /интерьергүй/ ашиглалтад оруулна. | Үндэсний археологи, угсаатны зүйн музей, лабораторийн барилга угсралтын ажлын явц 75%-тай хэвийн үргэлжилж байна.<br>Үндэсний археологи, палеонтологи, угсаатны музей, лабораторийн интерьерийн зураг төсөл 80%-ийн гүйцэтгэлтэй байна. | 01-12 сар | 100% |
| 3.4 | **Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт.**<br><br>Соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор төв, орон нутгийн соёл, урлагийн байгууллагын хүчин чадлыг нэмэгдүүлэх;<br>• Ашиглалтад орох барилгын тоо: 17, Үүнд:<br>• - Соёлын төв-6<br>• Номын сан-1<br>• Театр-2<br>• Музей-1<br>• Спорт заал-5<br>• Усан бассей-1<br><br>Аялал жуулчлалын цогцолбор-1 | Батлагдсан төсвийн дагуу санхүүжүүлнэ. | - | • Гэрээний дагуу Соёлын төв-6<br>• Номын сан-1<br>• Театр-2<br>• Музей-1<br>• Спорт заал-5<br>• Усан бассей-1<br><br>Аялал жуулчлалын цогцолбор-1 тус тус ашиглалтад оруулна. | 2025 онд ашиглалтанд орсон барилгуудаас:<br>• Спортын ордны барилга /Архангай, Эрдэнэбулган сум/<br>• Спорт заалны барилгын үлдэгдэл /Говь-Алтай, Тонхил сум<br>• Аймгийн хөгжимт драмын "Ойрад" театрын барилга /Увс, Улаангом сум/<br>• Аялал жуулчлалын мэргэжил сургалтын төв | 01-12 сар | 100% |
| 3.5 | **Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.1.10 дахь заалт.**<br><br>• "Дархан-Уул аймгийн Музей, номын сангийн цогцолборын интерьерийн зураг төсөл боловсруулах;<br>• Монголын Үндэсний археологи, палентологи, угсаатны музей, | Эдийн засаг, хөгжлийн сайдын багцын хүрээнд 708.2 сая төгрөгөөр санхүүжүүлнэ. | Зураг төсвийн ажлын гүйцэтгэл 40% | Иж бүрэн зураг төсвийг батлуулна. | • "Дархан-Уул аймгийн Музей, номын сангийн цогцолборын интерьерийн зураг төслийн боловсруулалт 100%<br>• Монголын Үндэсний археологи, палеонтологи, угсаатны музей, лабораторийн интерьерийн зураг төсөл- 80% гүйцэтгэлтэй.<br>• Дорнод аймгийн музейн интерьерийн ажлын зураг төсөл, төсөв нь БХТ-ийн 2024-06-07-ны өдрийн 807/2024 дугаар | 01-12 сар | 85% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | лабораторийн интерьерийн зураг төсөл; | | | | МЕД-ээр 1,319.1 сая төгрөгөөр хянан баталгаажсан.<br>• Өвөрхангай аймгийн музейн интерьерийн ажлын зураг төсөл, төсөв нь БХТ-ийн 2024-05-31 өдрийн 0768/2024 дугээр МЕД-ээр 1,622.7 сая төгрөгөөр хянан баталгаажсан.<br>• Говь-Алтай аймгийн музейн интерьерийн зураг төсөл, төсөв нь БХТ-ийн 2024-06-18 өдрийн 885/2024 дугаар МЕД-ийн 558.8 сая төгрөгөөр баталгаажсан. | | |
| 3.6 | **Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.1.11 дэх заалт.**<br><br>Барилга байгууламжийг хүчитгэх эрх зүйн орчныг шинэчлэн сайжруулж, улсын хэмжээнд байгаа түүх соёлын дурсгалт барилга байгууламжийг үе шаттайгаар бэхэлж, хүчитгэх ажлыг эхлүүлэх;<br>• Улсын драмын Эрдмийн Театрын барилгын хүчитгэн засварлах ажлын зураг, төсөл /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/<br><br>Байгалийн түүхийн музейн шинэчлэн засварлах /хуучнаар Лениний музей/; | Эдийн засаг, хөгжлийн сайдын багцын хүрээнд 631.2 сая төгрөгөөр санхүүжүүлнэ | Зураг төсвийн ажлын гүйцэтгэл 40% | Иж бүрэн зураг төсвийг батлуулна. | • "Байгалийн түүхийн музей /хуучнаар Ленин музей/-г шинэчлэн засварлах ажил"-ын, төсөв нь БХТ-ийн 2024-12-10-ны өдрийн 2253/2024 дугээр МЕД-ээр 13,033.5 сая төгрөгөөр хянан баталгаажсан.<br>• "Улсын драмын эрдмийн театрын барилгын хүчитгэн засварлах" ажлын зураг төсөл, төсөв нь БХТ-ийн 2024-05-31-ний өдрийн 0769/2024 дугээр МЕД-ээр 8,512.6 сая төгрөгөөр баталгаажсан. | 01-12 сар | 90% |
| 3.7 | **Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.3 дахь хэсэг.**<br><br>Богд хааны ордны цогцолборыг сэргээн засварлах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулах; | Батлагдсан төсөв-886.71 сая төгрөгийг санхүүжүүлнэ | Сэргээн засварлах ажлын гүйцэтгэл 50 хувь. | Барилгын засварын ажил 100 хувьд хүрсэн байна. | Барилга угсралтын ажил хэвийн үргэлжилж байна. 70% гүйцэтгэлтэй. 2025 онд багтаан ашиглалтад оруулна. Гүйцэтгэгч: Энэржин ХХК | 01-12 сар | 80% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.8 | **Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.3 дахь хэсэг.**<br><br>Чойжин ламын сүмийн цогцолборыг сэргээн засварлах ажлыг зохион байгуулах; | Батлагдсан төсөв-810.59 сая төгрөгийг санхүүжүүлнэ | Сэргээн засварлах ажлын гүйцэтгэл 50 хувь. | Барилгын засварын ажил 100 хувьд хүрсэн байна. | Барилга угсралтын ажил хэвийн үргэлжилж байна. 80% гүйцэтгэлтэй. 2025 онд багтаан ашиглалтад оруулна. Гүйцэтгэгч: Зэндмэнь суврага ХХК | 01-12 сар | 80% |
| 3.9 | **Монгол Улсын Засгийн газрын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.1.6 дахь заалт.** Хөвсгөл нуурыг түшиглэсэн “Хөвсгөл нуур музей, соёл мэдээллийн төв” | Ажлын гүйцэтгэл, хувь<br><br>Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан санхүүжилт | Барилга угсралтын ажил 70 хувьтай. | Засварын ажлыг бүрэн дуусгаж, хүлээлгэн өгсөн байна. | Хөвсгөлийн Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн "Санал хүргүүлэх тухай" 240 дүгээр албан бичгээр 9,02 га газрыг олгосон. Үзэсгэлэнт тайга ХХК-ийн 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 15 дугаар албан бичгээр Хөвсгөл-Хатгал-Жанай гэх газарт 18,7 га газрын кадастрын зураг хийсэн тухай албан бичиг ирүүлсэн. | 01-12 сар | 80% |
| 3.10 | Улсын драмын Эрдмийн Театрын барилгыг хүчилтгэн засварлах /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ **Монгол Улсын Засгийн газрын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.1.11 дэх заалт.** | Ажлын гүйцэтгэл, хувь<br><br>Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан санхүүжилт | Засварын ажил 70 хувьтай. | Засварын ажлын дуусгаж, хүлээлгэн өгсөн байна. | Улсын Драмын Эрдмийн Театрын барилгын их засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/-ын ажил дуусаж Улсын комисс 2024.04.10-ны өдөр комисс ажилласан.<br>"Улсын драмын Эрдмийн Театрын барилгын хүчитгэн засварлах ажлын зураг, төсөл /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ төсөл арга хэмжээ нь БХТ-ийн 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 0769/2024 дүгээр магадлалын ерөнхий дүгнэлтээр зураг төсөл, төсөв 8.512.641.084 төгрөгөөр хянан баталгаажсан тул 2026 оны төсвийн төслийн саналд хүргүүлэхээр ажиллаж байна. | 01-12 сар | 80% |
| 3.11 | Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын барилгын хүчитгэл, их засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/<br>**Монгол Улсын Засгийн газрын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.1.11 дэх заалт.** | Ажлын гүйцэтгэл, хувь | Батлагдсан зураг төсөвтэй. Гүйцэтгэгч шалгарсан. БАУ 80%-ийн гүйцэтгэлтэй. | Барилга угсралтын ажил 100 хувьд хүргэсэн байна. | Улсын дуурь бүжгийн эрмийн театрын хүчитгэл, засварын зураг төсөв БХТ-ийн 2023-05-31-ний өдрийн 757/2023 дугаар магадлалын ерөнхий дүгнэлтээр зураг төсөл, төсөв баталгаажсан. 2026 оны төсвийн төслийн саналд хүргүүлэхээр ажиллаж байна. | 01-12 сар | 85% |
| 3.12 | “Мэргэн Тоньюкук музей” барилга угсралтын ажлыг эхлүүлэх; | Холбогдох байгууллагуудтай хамтран хяналт тавьж, | Батлагдсан зураг төсөвтэй. Гүйцэтгэгч шалгарсан. | Барилга угсралтын ажил 100%-д хүргэнэ. | БНТУ-ын Засгийн газар болон Монгол Улсын ЗГ хоорондын Хөгжлийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээрийн хүрээнд Туркийн хамтын ажиллагаа, зохицуулах агентлагийн Улаанбаатар дахь Хөтөлбөр | 01-12 сар | 80% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | ажлыг эрчимжүүлнэ. | БАУ 30%-ийн гүйцэтгэлтэй. | | зохицуулалтын газар болон Эйч Эн Си Барилга ХХК хооронд Мэргэн Тоньюкукын музейн барилга угсралт, гадаад орчны тохижилт болон музейн үзэсгэлэнгийн танхимын тохижилтын барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээний дагуу "Мэргэн Тоньюкук музей" барилга угсралтын ажил 80%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. | | |
| 3.13 | **Монгол улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт.** Төсөвт өртөг нэмэгдсэн болон хугацаа сунгах төсөл, арга хэмжээний гэрээг байгуулах, хэрэгжилтийг хангах; | Төсөвт өртөг нэмэгдсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийн тоо-21 | 2024 онд төсөвт өртөг нэмэгдсэн 21, хугацаа сунгасан 22 төсөл арга хэмжээний гэрээг байгуулсан. | Ажлын хэсгийн хурлын шийдвэрийн дагуу гэрээ байгуулж, хэрэгжүүлнэ. | -Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн Хангайн бүсийг төрөлжсөн аялал жуулчлалын дэд бүс болгох тухай №182 тоот тогтоолын хүрээнд Архангай аймгийн Хөгжимт драмын театрын барилга /Архангай Эрдэнэбулган сум/ төсөл, арга хэмжээний гэрээний санхүүжилтийн дүнд өөрчлөлт оруулахгүйгээр ажлын нэршил, тоо хэмжээг шилжүүлэн зохицуулах нэмэлт гэрээг гүйцэтгэгчтэй байгуулах, барилга угсралтын ажлыг бүрэн дуусгах, шаардлагатай хөрөнгийн асуудлыг шийдвэрлэн ашиглалтад оруулах талаар Монгол Улсын Засгийн газрын 2024.04.14-ний 182 дугаар тогтоолын дагуу төсөл арга хэмжээний гэрээний үнийн дүнд өөрчлөлт орохгүй нэршлийг солих гэрээг нэмэлтээр байгуулсан. Гэрээний хугацаа 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл сунгасан, Гэрээний хугацааг сунгах нийт 29 гэрээг байгуулсан.Байгалийн түүхийн музейн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ БСШУСЯ/202001211 дугаартай төсөл арга хэмжээний барилга угсралтын ажлын явцад нэмэгдсэн А, Б блокийн ган бүтээц буулгаж, зэв арилгах, будах, угсрах ажлын гүйцэтгэл 8,113,328,446 төгрөгийг Монгол Улсын Засгийн 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 09 дүгээр тэмдэглэлд заасны дагуу 2025 оны батлагдсан төсөвт ажлын тоо хэмжээг 2026 онд хийгдэх ажлын тоо хэмжээгээр сольж зохицуулалт хийж гэрээнд өөрчлөлт оруулж 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн БСШУСЯ/202001211+1 дугаартай гэрээ байгуулсан. | 01-12 сар | 95% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
